## 11. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫН ХЭРЭГЖИЛТ( Ж-5.6, Х-3-4)

**1.Аймгийн ЗДТГ-ын үйл ажиллагааны ил тод,нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн дүн**

| д.д | Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал | | Хэрэгжүүлэлт | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|
| 1.1 | Дараах зүйлсийг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулж тогтмол шинэчилж байх: | - Байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийййн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ түүний үр дүн | Аймгийн ЗДТГ-ын эрхэм зорилгыг шинэчлэн хэлтэс, тасгийн хамт олноор хэлэлцэн батлаж цахим хуудас болон байгууллагын нэг давхарт ил тод байрлуулсан. Мөн ЗДТГ-ын үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө /2009-2012/ боловсруулан мөрдөн ажиллаж байна<br><br>ЗДТГазар стратегийн үндсэн 3 нь зорилт дэвшүүлэн 6 ангийн 98 нэр төрлийн бүтээгдхүүн нийлүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаа.<br><br>***uvs.mn, west.mn, chatsargana.mn, @prme.pmis.gov.mn*** сайтуудад үйл ажиллагаагаа сурталчлан ажиллаж байна. | 100 |
| | | - Албан хаагчийн ёс зүйн дүрэм | Засгийн газрын 1997 оны 58 дугаар тогтоолоор батлагдсан төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэм хэмжээг сахин ажиллаж байна. Тайлант онд байгууллагын албан хаагчдаас ёс зүйн болон албан ажилтай холбоотой зөрчил дутагдал гаргаагүй болно. | 100 |
| | | - Төрийн үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан | Овог, нэр:<br><br>Даваа овогтой Баярмаа | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | албан хаагчийн овог, нэр, албан тушаал, хариуцсан ажил, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь | Албан тушаал:<br><br>Иргэдийн эрэлт хүсэлт, ЗДТГ-ын дотоод ажил хариуцсан мэргэжилтэн<br><br>Хариуцсан ажил:<br>- Иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлт хүлээн авч шийдвэрлүүлэх<br>- ЗДТГ-ын газрын дотоод ажлын шуурхай байдлыг хангах<br>- Төрийн дээд болон аймгийн Засаг даргын шагналын асуудал<br>- Аймгийн ИТХ-ын ажлын албатай хамтран ажиллах<br>- Нээлттэй хаалганы өдөр, нээлттэй утас, саналын хайрцаг ажиллуулах, нэг цонхны үйлчилгээ<br>Харилцах утас:<br>- 99458387, 9301 24718,<br>Иргэдийг хүлээн авах цагийн хуваарь:<br><br>- Ажлын өдөр бүр ажлын цагаар | |
| | | - Төрийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт | - Иргэний үнэмлэх<br><br>- Эрүүл мэндийн дэвтэр<br><br>- Даатгал, халамж үзүүлэхэд шаардагдагдах бусад бичиг баримтууд | 100 |
| | | - Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа хууль, тогтоомж, дүрэм, журам, заавар | - Төрийн албаны тухай хууль<br><br>- ЗЗНДНТУ-ийн тухай хууль<br><br>- Хөдөлмөрийн тухай хууль<br><br>- ЗДТГ-ын дотоод журам<br><br>- Салбарын хуулиуд<br><br>- Бусад тогтоол шийдвэрүүд | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| 1.2 | - Тухайн байгууллагаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээний арга хэлбэрийг боловсронгуй болгох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх | Аймгийн Засаг даргын 2007 оны 399 дугаар захирамжаар "Нээлттэй хаалганы өдөр"-ийг зохион байгуулах байнгын ажлын хэсгийг аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулан ЗДТГ-ын хэлтсийн дарга нарын бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж байна .<br><br>Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн үндсэн 5 зорилтын хүрээнд төрийн байгууллагын үйл ажиллагаа нээлттэй , ил тод, төрийн үйлчилгээг шуурхай , чанар хүртээмжтэй хүргэх, төрийн захиргааны бүх шатны байгууллагууд иргэдийн санал зөвлөгөөг сонсож , төр засгийн бодлого боловсруулах , шийдвэр гаргахад тусгах зорилт тавин ажиллаа.<br><br>Энэ арга хэмжээнд 109 байгууллага, 19529 иргэд хамрагдаж , 913 санал хүсэлт хүлээн авч, 694 буюу 76,1%-ийг шийдвэрлэж, төрийн үйлчилгээний талаар иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг 856 иргэнээс авч, 6760 гарын авлага, сурталчилгааны материалаар үйлчлэн ажиллаа.<br><br>Дотоод шийдвэр нь илтод, ажлын гүйцэтгэлд чиглэсэн суралцагч байгууллагыг хөгжүүлэхийн тулд долоо хоног бүрийн Баасан гаригт ЗДТГ-ын аппаратын шуурхай цуглаан, мөн Даваа гариг бүрт төсвийн болон аж ахуйн байгууллагын удирдлагуудын нэгдсэн цуглаан тус тус зохион байгуулж төр засаг, аймгийн ИТХ, Засаг даргын шийдвэрүүд танилцуулах, тэдний санал хүсэлтийг хүлээн авах ажлыг зохион байгуулах ажил хэвшил болоод байна. | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| 1.3 | - Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хуулиар хориглоогүй аливаа мэдээллийг иргэдэд үнэ төлбөргүй, хүндрэл чирэгдэлгүй өгөх, зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх | - Төр, засгийн болон аймгийн ИТХ, Засаг дарга, түүний Тамгын газраас гаргасан аливаа шийдвэрийг орон нутгийн МВС, САМА телевез, FM радиогийн сувгаар олон нийтэд мэдээлэх ажлыг 7-14 хоног тутамд тусгай графикийн дагуу тогтмол мэдээлэх ажил хийгдээд байна. | 100 |
| 1.4 | Нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрээ тухай бүр Хууль зүй, дотоод хэргийн яамаар хянуулан, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулсан байх | 2009 онд аймгийн Засаг даргаас нийтээр дагаж мөрдүүлэх захирамж гараагүй ба ХЗДХ-ийн яаманд бүрдгүүлсэн шийдвэр байхгүй байхгүй болно.<br>Сумдын ЗДТГ-аасбагуудад төр засгийн болон аймаг, орон нутгийн бодлого шийдвэрийг иргэдэд хүргэх “Аялах хайрцаг”-ийг аялуулах ажил хэвшил болоод байна. | 100 |
| 1.5 | Төрийн бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төсөл боловсруулахдаа холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авч үндэслэлтэй гэж үзвэл төсөлд тусгадаг байх | - Аймгийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулахаар 80 гаруй хүний бүрэлдхүүнтэй төв болон салбар ажлын хэсэг байгуулан ажилласан. Хөтөлбөр боловсруулахад төрийн ба иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл, зарим эрдэмтэд болон иргэдийн санал авч тусгасан болно. | 100 |
| 1.6 | Санал, хүсэлт, өргөдөл, гомдол мэдээлэл хүлээн авах утас буюу хайрцаг ажиллуулан, түүний мөрөөр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх | Аймгийн хэмжээгээр төрийн байгууллагуудад ард иргэдийн санал асуудлыг хүлээн авах “Нээлттэй утас” , санал хүсэлтийн хайрцаг ажиллуулах, байгууллагынхаа чиг үүрэг, эрхэм зорилго, үйл ажиллагааг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлууд жилийн турш хийгдэж тогтмолжиж байна. | 100 |
| 1.7 | Өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлэж, хариуг өгч хэвшсэн байх | Аймгийн хэмжээнд 11376 санал өргөдөл гомдол хүлээн авсанаас 10885 буюу 96.6 хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажилласан байна. Үүнээс аймгийн ЗДТГ-т 605 иргэнээс өргөдөл ирүүлсэний 93.7 хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. Аймгийн Засаг дарга бүрэн | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| | | эрхийнхээ хүрээнд 202 иргэнд 9.4 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж, 24.6 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. | |
| | ДУНДАЧ ХУВЬ | | 100 |

**2.Хүний нөөцийн бодлогын ил тод байдлын хэрэгжилт**

Төрийн албаны хүний нөөцийн ил тод байдлыг хангахын тулд төрийн захиргааны албаны сул ажлын байрны захиалгыг сум агентлагуудаас жилд 2-оос доошгүй удаа авч нийтэд зарлан Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтыг зохион байгуулан явуулж байна.

Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт зохион байгуулж явуулахдаа шалгалт авахаас нэг сарын өмнө Зууны мэдээ сонин, орон нутгийн радио , телевиз, сум байгууллагын мэдээллийн самбарт шалгалт авах ажлын байр, шалгалт авах чиглэл, шалгалтын хуваарь, график, шалгалтанд орох иргэдийн бүрдүүлэх материал зэргийг тусгасан дэлгэрэнгүй мэдээлэл тавьж иргэдэд хүргэж байна.

Төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүнг ТӨрийн албаны зөвлөлийн Веб хуудсанд ил тод тавьж иргэдэд мэдээлэл өгч байна.

2009 онд Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтыг 3 удаа зохион байгуулж 163 ажын байранд 855 иргэнийг бүртгэн шалгалтанд хамруулснаас 497 иргэн тэнцсэн байна. Одоогийн байдлаар 159 ажлын байранд томилгоо хийгдээд байна.

Төсвийн Ерөнхий менежерийн ажлын байр сул чөлөөтэй болсон тохиолдолд төрийн албаны зөвлөлийн 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн байгууллагын ерөнхий менежерийн үүрэг гүйцэтгэх дарга, захирал , эрхлэгч”-ийг сонгон шалгаруулах журмыг баримтлан сонгон шалгаруулалт явуулахаас нэг сарын өмнө зарлал мэдээлэл гаргаж, сум байгууллагуудад хүргүүлэн зохион байгуулж байна.

2009 онд Хяргас , Наранбулаг, сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга , Сагил, Цагаанхайрхан, Өлгий сумдын Засаг даргын тамгын газрын дарга, аймгийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтсийн даргын ажлын байранд сонгон шалгаруулалт зохион байгуулан явуулж, холбогдох ажлын байруудад томилгоо хийлээ. Байгууллагын хүний нөөцийн ил тод байдал 100 хувийн хэрэгжилттэй байна.

**3.Төсөв санхүүгийн ил тод байдлын хэрэгжилт**

Аймгийн Засаг даргын тамгын газар нь төсөв санхүүг зөв зохистой зарцуулах талаар Сангийн яамны 2005 оны 124 дугаар тушаал, тайлагнах мэдээлэх талаар Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолыг удирдлага болгон ажиллаж байна.

Тус байгууллага нь 2009 онд 539.7 сая төгрөгний санхүүжилт авч 61 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулан цалингийн зардалд 296.9 сая төгрөг, гэрэл цахилгаан, цэвэр бохир ус, түлш халаалтын зардалд нийт 60.1 сая төгрөг, бусад бараа үйлчилгээний

зардалд 119.1 сая төгрөг, жижиг эд хогшил худалдан авахад 17.9 сая төгрөг, хөтөлбөр ага хэмжээний зардалд 22.8 сая төгрөг зарцууллаа.

Байгууллагын ажилтан, ажилчид, өндөр настанд түлш нүүрсний хөнгөлөлт 8.9 сая төгрөг, үр дүнгийн урамшуулал 7.6 сая төгрөг, давхардсан тоогоор 32 хүнд 3.2 сая төгрөгний тусламж дэмжлэг , 9.1 сая төгрөгний тоног төхөөрөмж, 8.7 сая төгрөгний тавилга шинээр нэмж худалдан авлаа.

Аймгийн Аудитын газраас аймгийн Засаг даргын тамгын газрын 2006, 2007. 2008 оны санхүүгийн үйл ажиллагаа, тайлан, баримтад гүйцэтгэлийн аудит, УМХГ –аас 2007, 2008, 2009 оны баримтад гүйцэтгэлийн шалгалтыг тус тус хийлээ. Төсөв санхүүгийн ил тод байдал 100 хувийн хэрэгжилттэй байна.

**4.Аймгийн Засаг даргын тамгын газрын бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлын хэрэгжилт**

Аймгийн Засаг даргын тамгын газар нь 2009 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөнд тусгагдсан бараа, ажил үйлчилгээг гүйцэтгэхдээ ТБОНӨБАҮХА тухай Монгол улсын хууль, Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолыг удирдлага болгон ажиллаа.

Аймгийн Засаг даргын тамгын газрын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд парк шинэчлэл 81.1 сая төгрөг, аймгийн Засаг даргын тамгын газрын байрны засвар тохижилтонд 50.0 сая төгрөгийг тус тус төлөвлөсөн бөгөөд аймгийн Засаг даргын суудлын автомашин шинэчлэхэд зориулан нийлүүлэх автомашины тендерийг ТБОНӨБАҮХА тухай хуулийн дагуу нээлттэйгээр Сангийн Яамны цахим хуудас, өдөр тутмын сонин, орон нутгийн сонин телевиз болон ЗДТГ-ын мэдээллийн самбарт зарлан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж 81.1 сая төгрөгөөр гэрээ байгуулан нийлүүллээ.

Хуулийн дагуу засвар тохижилтын ажлын тендэрийг харьцуулалтын аргаар ил тод зохион байгуулж , засвар шинэчлэлийн ажилд “Увс-Өргөө” ХХК шалгаран 16.2 сая төгрөгөөр аймгийн ЗДТГ-ын хурлын заалны засвар, сантехникийн засвар, шинэчлэлийн ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Тоног төхөөрөмж, техник хэрэгсэл нийлүүлэх 33.8 сая төгрөгний тендэрт “Увс-Софт” ХХК шалгаран гүйцэтгэж, хурлын зориулалтын иж бүрэн ширээ сандал, техник хэрэгсэл бусад тоног төхөөрөмжийг нийлүүлж суурилууллаа. Энэхүү ажил 100 хувийн хэрэгжилттэй байна.

УВС АЙМГИЙН ЗДТГ-ЫН ДАРГА Д.ЦОГТ-ОЧИР